

## **ТОГТООЛЫН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

2026-05-04

**Ерөнхий мэдээлэл:** Ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээ” гэдэг нь тухайн зүйл ургамлын оршин амьдрах нөхцөл болон экологийн, эдийн засгийн, эрх зүйн, ач холбогдлоор нь үнэлсэн тусгай аргачлалын дагуу тооцсон нэгж, жингийн мөнгөн үнэлгээ юм. Байгаль орчин Уур амьсгалын Өөрчлөлтийн Сайдын 2025 оны “Экологи эдийн засгийн үнэлгээ батлах тухай” А/75 дугаар тушаалаар нэн ховор, ховор, зарим элбэг ургамлын экологи эдийн засгийн үнэлгээг шинэчилэн баталсан. Уг тушаалд ургамлын зүйлийн статусыг зөвхөн хуульд заасан нэн ховор, ховор, элбэг гэж тооцохоос илүүтэй, тэдгээрийн улаан дансны ховордлын /Устаж байгаа (CR), Устаж болзошгүй (EN), Эмзэг (VU)/ ба ховордлын бус зэрэглэлийг харгалзаж мөн унаган болон завсрын унаган, үлдвэр, харь зүйл гэх зэрэг бусад статусаар ангилж ургамал бүрийн ашиглалтын нөөцөд тухайн зүйл ургамлын хэрэглэгдэх эрхтэн, борлуулалтын дүйцүүлэх үнэ, хаталтын хувь буюу нойтон жин, бүсийн байршил зэргийг ялгаатай тусгасан нь шинжлэх ухаан, практикийн өнөөгийн эрэлт хэрэгцээг бүрэн хангасан ургамлыг бодитой үнэлэх аргачлал болсон давуу талтай.

**Өнөөгийн төлөв байдал:** Дархан-Уул аймаг нь ургамал газар зүйн хувьд Монгол дагуурын уулын ойт хээрийн тойрог, Хэнтийн уулын тайгын тойрогт (Грубов) хамаардаг бөгөөд байгалийн ургамлын зүйлийн бүрдэл ихтэй. Гэвч уур амьсгалын өөрчлөлт, бэлчээрийн хэт их ашиглалт, уул уурхай, мод бэлтгэл, хууль бус ашиглалт худалдаанд түгээмэл өртөж буйн улмаас байгалийн ургамлын тархац буурч, нөөц багассан. Аймгийн нутаг дэвсгэрээс сүүлийн жилүүдэд хууль бусаар ашигт ургамлыг их хэмжээгээр түүх явдал ихэсч байна. Аймгийн хэмжээнд 2024-2025 онд ургамлын аймгийн нэгдсэн судалгаа , ургамлын ашиглалтын нөөцийг тогтоосон бөгөөд хэлэлцүүлгийн үеэр тодорхой танилцуулга хийгдэнэ.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Дархан

“Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн  
хувь хэмжээг шинэчлэн тогтоох тухай”

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, Байгаль орчин, Уур амьсгалын Өөрчлөлтийн Сайдын 2025 оны А/75 дугаар тушаалыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1. “Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ”-г хавсралтаар баталсугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Б.Азжаргал/-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2024 оны “Байгалийн ургамал ашигласны төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 04 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

А.ЯНЖМАА

**АЙМГИЙН ИТХ-ААС ТОГТООХ ТӨЛБӨРИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ:**

Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар байгалийн ургамал түүж бэлтгэхэд төлөх төлбөрийн хэмжээний дээд доод хязгаарыг статусаар нь тогтоож өгсөн байдаг.

Хүснэгт 1. Ургамал ашигласны төлбөрийн хувь хэмжээ, ашиглалтын хэлбэр, зөвшөөрөл олгох явц

№	Төлбөр тооцох ургамлын статус	Төлбөр тооцох үзүүлэлт (ургамлын ЭЭЗҮ-ний хувиар)		Ургамал ашиглах хэлбэр	Зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага
		доод	дээд		
1	Нэн ховор	25%	30%	Судалгаа шинжилгээний зориулалтаар	Байгаль орчин Уур амьсгалын Өөрчлөлтийн Яам
2	Ховор	15%	20%	Судалгаа шинжилгээ, эм үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах	Байгаль орчин Уур амьсгалын Өөрчлөлтийн Яам
				Иргэн ховор ургамлыг өөрийн ам бүлийн хүнсний болон ахуйн бусад хэрэгцээг хангах зорилгоор ашиглах	Сум, дүүргийн Засаг дарга
3	Элбэг	5%	10%	Элбэг ургамлыг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах	Аймаг, нийслэлийн байгаль орчны албаны дүгнэлтийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга

Жишээ: Төлбөрийн хувь хэмжээ тооцсон үзүүлэлт

№	Ургамлын зүйлийн нэрс		Статус	Төлбөр тооцох хувь /%/		Ургамлын төлбөр тооцох ЭЭЗ-ийн суурь үнэлгээ /мян.төг/		Төлбөрийн хэмжээ /дээд /		Төлбөрийн хэмжээ /доод/	
	монгол	латин		дээд	доод	Хуурай /кг/	Нойтон /кг/	Хуурай /кг/	Нойтон /кг/	Хуурай /кг/	Нойтон /кг/
1	Булцуут түдэнхавх	Calypso bulbosa (L.)	Нэн ховор	30	25	104300	75100	31290	22530	26075	18775
2	Том цэцэгт саадгана	Cypripedium macranthum				222600	142500	66780	42750	55650	35625
3	Шар саадганцэцэг	Cypripedium calceolus				165200	105800	49560	31740	41300	26450
4	Эмийн бамбай	Crepis czuensis	Ховор	20	15	215500	86200	43100	17240	32325	12930
5	Альбертийн сарнай	Rosa Beggeriana				28022	13170	5604	2634	4203	1975
6	Халиар сонгино	Allium victorialis				164200	65700	32840	13140	24630	9855
7	Сарьслаг хунчир	Astragalus membranaceus	Элбэг	10	5	193400	108300	19340	10830	9670	5415
8	Эгэл гоньд	Carum carvi L.				105300	50600	10530	5060	5265	2530
9	Хавтаг навчит хус /навч/	Betula platyphylla Sukacz.				153000	85700	15300	8570	7650	4285

-----oOo-----